

ӨСВӨР, ЗАЛУУ ТАМИРЧДЫГ БАГА НАСНААС НЬ СИСТЕМТЭЙ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Д.Халзан, МУБИС
О.Гэрэл, БСШУСЯ

Abstract

It is highly required to meet the world standard while professionalism in volleyball starts with the selection of children at their young age and to provide them with proper training and make them fully understand what their future goal needs to be in order to become professional players. To achieve excellent results, kids need to be trained in the systematic ways and trainers need to use the most updated programs and techniques.

The highly developed countries improves the athletic running, policy maintainence, and organization of sustainable trainings among school and college students. There is a multi-lateral relationship between various organizations like science, culture and athletic organizations to motivate and make young generation love and do trainings in various types of athletical activities and it also becomes the important aspect to prepare new generation in the future. On the base of the pyramid, the athletes seek sponsors and seek for the foundation themselves. If teams are equal in talent, the team that has the mastery of fundamentals will win the other.

Түлхүүр үг

Өсвөр үе, залуучуудын спорт, боловсрол, шинжлэх ухаан, төлөвлөлт, тогтолцоо

Удиртгал

Монголын тамирчид 1964 оны өвөл, зуны олимпод оролцсон цагаас олимпын хөдөлгөөнд идэвхтэй оролцож зуны олимпоос алтан медаль 3, мөнгөн медаль 7, хүрэл медаль 10-ыг хүртсэн амжилт үзүүлээд байна. Сүүлийн жилүүдэд олимп, дэлхий, тивийн тэмцээнээс медаль хүртэх тамирчдын тоо жилээс жилд өссөөр байгаа нь эрс тэс уур амьсгалд дасан зохицсон, байгалаас заяасан Монгол тамирчдын хүчтэй гени, ур чадвар, сургалт дасгалжуулалтын ажилд гарч буй хөгжил, дэвшил хүчтэй нөлөөлсөөр байна.

Улс орны нийгэм эдийн засгийн байдал, хөгжлийн түвшинг дагалдан Биеийн тамир спортын салбарын хөгжил нягт уялдаатай явагддаг нь хэн бүхэнд ойлгомжтой билээ.

Өсвөр, залуу тамирчдын дунд зохиогдож буй спортын тогтолцооны өнөөгийн байдал

Сүүлийн жилүүдэд манай тамирчдын амжилт, ур чадвар эрс өсөж олимп, дэлхий, тивийн тэмцээнээс медаль хүртэх төрөл, тамирчдын тоо жилээс жилд өссөөр байна. Спортоор сонирхон хичээлдэгсдийн тоо эрс өсөж идэвхтэн дасгалжуулагчид, спорт дэмжигчид ивээн тэтгэгчдийн тоо тасралтгүй нэмэгдсээр байна. Үүнтэй уялдан спортын материаллаг баазыг шинэчлэн тохижуулах, шинээр барих,

стадион, задгай талбай ашиглах нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохиох, олон улсын стандартад нийцэх спортын барилга байгууламжийг байгуулахад төр засгаас дорвитой арга хэмжээ авахгүй байсаар байна.

Нийслэл хот 1950-аад оны сүүлчээр төв цэнгэлдэх хүрээлэнтэй болж, 4 дүүрэг бүрд 400 м-ийн тойрог бүхий стадион, хүүхдийн паркт иж бүрэн тоноглогдсон цэнгэлдэх хүрээлэн, ЕБС-ийн сургууль бүр биеийн тамирын талбай, их, дээд сургууль бүр хөнгөн атлетикийн төрлүүд, спорт тоглоом хичээллэх боломжтой биеийн тамирын талбай, орон сууцны томоохон хороолол бүр стадион, хөл бөмбөгийн талбайтай байсан бол өнөөдөр бүрэн устаж дээр нь орон сууц барьснаар, эргэн тойрон барилгаар шахагдсан ганц Төв цэнгэлдэх хүрээлэн жилд ганц удаа болдог Үндэсний баяр наадам зохиогдох төдийгөөр ашиглалтгүй шахам байна.

Хүүхэд залуучуудын паркт үйлдвэр албан байгууллагын өдөрлөг, сургуулийн хавар намрын спартакиад, иргэдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, амралтын хүрээлэн нь шуналтай хүмүүсийн хараанд аль хэдийн өртөж нураагдсан эмгэнэлт хувь заяанд өртсөөр хэдэн жилийн нүүр үзэж байна. Лав л стадион барихаар нураагаагүй нь тодорхой. Өнөөдөр нийслэл хотод хөнгөн атлетикийн

төрлийн бэлтгэл сургууль явуулах боломжтой стадион, биеийн тамирын гадаа талбай байхгүй 20 гаруй жилийн нүүр үзэж байна.

Бага насны хүүхдүүд спортоор хичээллэх сонирхол эрс өссөн өнөөгийн нөхцөлд ЕБС-иуд спортын заал танхимаар бүрэн хангагдаагүй, биеийн тамирын багшийн ажлын үнэлгээ хангалтгүй байгаагаас хичээлээс гадуурх секц, дугуйлангийн хичээлийн чанар хангалтгүй, авьяаслаг өсвөрийн тамирчдыг нээн илрүүлдэг уламжлал алдагдахад хүрч магадгүй байна.

Хүүхэдтэй ажиллах идэвхтэй дасгалжуулагчид спортын төрөл бүрд олширч байгаа боловч тэдний ажлыг үнэлэх үнэлгээ, урамшууллын тогтолцоо боловсронгуй болгох арга хэмжээ авахгүй, цагийн хөлсний тариф, амралт баяр ёслолын цагаар ажилласны хөлс олгогдохгүй байгаа нь зах зээлд шилжээд 28 жилийн нүүр үзэж буй Монгол оронд спортын салбарт шинэчлэл, өөрчлөлт удаашралтай явж байгаагийн илрэл бөгөөд төр засаг бодлогоор шуурхай арга хэмжээ авч, дэлхийн улс орнуудын жишигт ойртож ажиллахыг нийгмийн хөгжил, иргэдийн зүгээс зүй ёсоор шаардаж байна.

Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбар нэг яамны бүтцэд орж, удирдлага зохион байгуулалтын тал дээр бодлогын нэгдмэл үйл ажиллагаа, нэгдсэн шийдвэр гарах болсон таатай нөхцөлийг ашиглан нэгдсэн нэг удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж ажиллах сайхан боломж нээгдлээ.

Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын байгууллагын удирдлагын идэвх санаачилга хангалтгүй, спорт өндөр хөгжсөн орнуудын туршлагыг өөрийн оронд бүтээлчээр авч хэрэгжүүлэх ажил хоцорч, ажлын уялдаа холбоо тааруу, эрх зүйн зохицуулалт хангалтгүй, төрөөс шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулахад дэмжихгүй байгаатай холбоотой юм.

Төр засгаас хүүхэд залуучуудын спортод дэлхийн жишигт хүрсэн шинэчлэл, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж, спорт өндөр хөгжсөн орны орчин нөхцөлийг бүрдүүлэхэд шат дараатай арга хэмжээг төлөвлөн, хөрөнгө санхүүжилтийг шаардлагатай хэмжээнд шийдэх хэрэгтэй.

ЕБС, их дээд сургуулийн дэргэд спортын төрөлжсөн клубүүд олноор байгуулах шаардлагатай болжээ. Хувийн хэвшлийн сургуулиудаас “Аварга” биеийн тамирын дээд сургууль ахлах сургууль байгуулж өсвөр залуучуудын шилдэг тамирчдыг бэлтгэж, “Этүгэн” дээд сургууль оюутнуудынхаа дунд сагсан бөмбөгийн “Этүгэн ирвэс” клуб байгуулж,

өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн Лигийн баг хичээллүүлж, амжилтад хүрч буй туршлагыг их дээд сургуульд хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Энэ чиглэлээр Монголын оюутны спортын холбоо, Монголын залуучуудын холбоо, их дээд сургуулийн консорциум, төрийн болон хувийн их, дээд сургуулиуд идэвх санаачилга гаргаж, хамтран ажиллаж нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нэг сая гаруй хүнтэй нийслэл хотод спортын төрөлжсөн сургалттай сургууль ганцхан байгаа боловч, дотуур байргүй, хөнгөн атлетикчид хичээллэх талбайгүй, дүүргүүдэд спортын сургуулиуд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин хангалтгүй, хичээлийн агуулга, хөтөлбөр, хичээлийн сурах бичиг боловсруулагдаагүй байгаа нь тамирчдын залгамж халааг бэлтгэх, шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт, дасгалжуулалтын үйл ажиллагаа явагдах нөхцөлийг бий болгоход саад тээг болсоор байна.

Хүн амын тоогоор 2-3 аймгийн хүнтэй тэнцэх 200.000-300.000 хүнтэй дүүргүүдэд нэг ч спортын сургууль байхгүй байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Манай улсад спортын салбарт хамгийн их хоцрогдож байгаа зүйл бол өсвөр үеийнхний дунд явуулах спортын сургууль, гүнзгийрүүлсэн болон спортын тусгай анги бүлэг, спортын ахлах сургууль, олимпын нөөц бэлтгэх сургууль, төрөлжсөн спортын клубүүд, их дээд сургуулиудын оюутнуудын дунд явагдах спортын тэмцээн, наадмын тогтолцоо алдагдаж, зарим их дээд сургуулиудын дэргэдэх спортын секц, дугуйлангууд долоо хоногт дөнгөж 1-2 удаа хичээллэдэг, биеийн тамирын хичээлийн сургалтын чанар тааруу байгаа нь 40-өөс дээш насны хүний биеэ чийрэгжүүлж, эрүүл мэндээ хамгаалахад хийх шаардлагатай 7 хоногийн ачааллаас ч бага үзүүлэлт юм.

Дэлхийн ихэнх их дээд сургуулийн оюутнууд 7 хоногт 5-аас доошгүй удаа бэлтгэл сургууль хийж томоохон клубүүд, улсын шигшээ багийн залгамж халаа их дээд сургуулийн оюутнуудаас бэлтгэгддэг жишиг нэгэнт спорт өндөр хөгжсөн улс оронд тогтоод байна (Kinda S.Gsher, 1997).

Манай улсын төрийн мэдлийн их дээд сургуулийн оюутнуудын дунд явагддаг спортын секц дугуйланг спорт өндөр хөгжсөн орнуудын их дээд сургуулийн спортын дугуйлангийн цаг, ачааллыг 1, 2-р хүснэгтээр харьцуулан үзүүлбэл:

Хүснэгт 1

Манай улсын төрийн мэдлийн их дээд сургуулийн оюутны 7хоногт хичээллэх секцийн хичээлийн тоо, цаг

Их, дээд сургууль	Спортын төрөл бүрийн 7 хоногт хичээллэх тоо	Хичээллэх цаг
МУИС	2-3 удаа	4-6 цаг
ХААИС	2-3удаа	4-6цаг
МУБИС	1-2удаа	1.5-3цаг
АУИС	1-2удаа	2-4цаг
ХЦИС	2удаа	4цаг
БХИС	2удаа	4цаг

Хүснэгт 2

Спорт өндөр хөгжсөн орнуудын их дээд сургуулийн оюутнуудын 7 хоногт хичээллэж буй секцийн тоо, цаг

Улс	7 хоногт хичээллэх тоо	Хичээллэх цаг
ОХУ	5 удаа	10 цаг
АНУ	5 удаа	10 цаг
БНХАУ	5-6 удаа	12- 18 цаг
Япон	5-6 удаа	12- 18 цаг
Өмнөд Солонгос	5-6 удаа	12 -18 цаг

Хүүхдийг бага наснаас нь спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг төрүүлж бэлтгэх асуудал сурган хүмүүжүүлэх маш нарийн тогтолцооны асуудал юм. Спортын залгамж халаа бэлтгэх тогтолцоо нь нэгдсэн системтэй тодорхой зорилгыг агуулсан зохион байгуулалтын нарийн удирдлагын дагуу явагдах, байнга боловсронгуй болгох нийлмэл асуудал юм. Залгамж халаа бэлтгэх тогтолцоо нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байгууллагын нягт хамтын ажиллагааны үр дүнд бий болох олон талт үйл ажиллагаа юм (Никитушкин, Квашук, Вауэр, 2005, с.3).

Орчин үед спортоор эхлэн хичээллэх нас залуужиж зарим спортод 4-6 наснаас эхэлдэг болсон нь ЕБС-ийн 1-р ангиас эхлэн сонгож хичээллүүлэх зорилт, хэрэгцээ шаардлага урган гарч байна. Иймээс дэлхий дахинд өсвөр тамирчдыг бага наснаас нь бэлтгэх асуудал спорт өндөр хөгжсөн улс бүрийн анхаарлын төвд байж, цэцэрлэг, сургуулийн наснаас 12-р анги төгсгөл олон жилийн системтэй бэлтгэх хандлагад шилжиж эхэлсэнтэй холбогдуулан Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамны хамтын нягт нямбай ажиллагаа, удирдлага зохион

байгуулалтын шинэчлэлийн үр дүнд бүрэлдэн тогтох асуудал болж байна. Өсвөрийн тамирчид бэлтгэх асуудал олон жилийн тасралтгүй бэлтгэлийн үр дүнд бий болж бага балчир наснаас эхлэн 15-20 жилийн урт хугацааны тасралтгүй бэлтгэлийн үр дүнд өндөр зэрэгтний эгнээнд шилждэг байна (Анатолий Бондарчук, 2017, с135-136).

Спортын практикаас харахад, хүүхдийг анх сонгон бэлтгэснээс хойш 5-7 жилийн дараа анхны амжилт үзүүлж, цаашид тогтвортой хичээллэсэн нөхцөлд өндөр ур чадварт хүрч, 12-18 жилийн дараа амжилт нь тогтворжин дээд амжилт үзүүлэх буюу цаашид буурч эхэлдгийг судлаачид тогтоожээ (Волков, 1984).

Спортын залгамж халаа бэлтгэх олон улсын чиг хандлага

Олимпын тоглолтод тэргүүлэх байранд өрсөлдөж буй АНУ, БНХАУ, ОХУ, Япон, Германы туршлагаас харахад спортын дунд болон ахлах сургууль, спортын бүлэг, олимпын нөөц бэлтгэх сургууль, төрөлжсөн спортын клубүүдэд онцгой анхаарал тавьж үр дүнд хүрч буй дэлхийн жишгийг анхаарах нь зүйтэй. Олимпын наадамд тэргүүлэх чиглэлээр өрсөлддөг Америкийн Нэгдсэн Улсын хүүхдийн спортын тусгай сургуулиас шилдгүүдийг сонгон олимпын бэлтгэлийн төвдөө жил бүр 6 сарын хугацаатай олимпын бэлтгэлийн төвдөө урьж, өндөр зэрэглэлийн дасгалжуулагчийн гар дээр хичээллүүлэн 12-16 жилийн дараах олимпод оролцох баг тамирчдаа урьдчилан бэлтгэдэг арга нь улс орнуудын дасгалжуулагчдын анхаарлыг зүй ёсоор татдаг авууштай туршлага юм.

ОХУ, АНУ-д оюутны спортод онцгой анхаарч оюутны лигийн тэмцээнийг маш өндөр хэмжээнд зохион байгуулж улсын шигшээ баг, мэргэжлийн клубүүдэд тоглох залуу тамирчдыг олж тодруулдаг онцлогтой. БНХАУ дээрх орнуудын хамгийн шилдэг гэсэн арга туршлагаар өсвөрийн тамирчдаа бэлтгэж буй онцлог нь сүүлийн 4 олимпын тоглолтод үзүүлсэн үсрэнгүй амжилтаас тодорхой харагдаж байна.

Сүүлийн олимпын тоглолтод оролцож буй амжилтын үндэс нь хүүхдийг бага наснаас нь сонгон спортын дотуур байртай сургуулиар дамжуулан тасралтгүй хичээллүүлж дэлхийн спортын оргил амжилтад хүрч буйг спорт сонирхогчид мэднэ (Сүхбат, 1997, х.3). Спортын амжилт үзүүлэх нөхцөл нь жилд 1200-1900 цагийн бэлтгэл сургууль хийх, тухайлбал дугуй спорт жилд 42 мянган км, цанын төрөлд жилд 10 мянган км, спортын гимнастик 2000 орчим комбинац, спорт тоглоомын төрлүүд 500 орчим техник тактикийн суурь бэлтгэл хийж байж,

өндөр зэрэглэлийн тамирчид бэлтгэгддэг байна (Волков, 1984). Спортын амжилт үзүүлэх нөхцөл нь тусгайлан байнгын тасралтгүй бэлтгэл сургуулилтаар хангаж, жилд оролцох уралдаан тэмцээн, наадам, тоглолтыг нарийн төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу төлөвлөж байж ур чадвартай тамирчин бэлтгэх асуудал яригдана.

Дэлхий дахинд спортын залгамж халаа бэлтгэх асуудлаар тэргүүлдэг АНУ, БНХАУ, ОХУ, Япон зэрэг орнууд хот, муж бүртээ хүүхэд залуучуудын спортын сургууль клубүүд, спортын ахлах сургууль байгуулж тэдгээрээс төрөн гарсан тамирчдыг их дээд сургуульд суралцах үед нь спортын тэтгэлэг олгон тасралтгүй бэлтгэл сургууль хийх боломжоор ханган, улсын аварга шалгаруулах шатлал бүхий тэмцээн, лигүүд, оюутны лигүүдэд оролцуулдаг уламжлал хэдийн тогтжээ (Халзан, 2005, х.68). Ялангуяа Боловсролын байгууллага ЕБС-ээс авхуулаад их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын системд онцгой анхаарч, хүүхэд залуучуудын спортод бодлогоор дэмждэг болоод байна.

Өнөөгийн байдал тулгамдсан асуудлууд

Манай улсад жүдо, чөлөөт бөх, бокс, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөгийн спортын төрлүүдээр бага насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах сургалт дасгалжуулалтын ажилд чанарын ахиц гарч идэвхтэн дасгалжуулагчийн тоо нэмэгдэн, ивээн тэтгэгч байгууллага хүмүүсийн тоо олширлоо. 7 аймагт хүүхдийн спортын сургууль байгуулагдан ажиллаж байна. Харин сая гаруй хүнтэй нийслэл хотод спортын төрөлжсөн сургалттай сургууль үйл ажиллагаа явуулж байгааг нэмэгдүүлэн нийслэлийн дүүргүүдэд спортын төрөлжсөн сургалттай сургууль, клубүүд олноор байгуулахыг дэмжих ёстой.

Олон хүнийг хамран хичээллүүлдэг нийтлэг спорт тоглоомын төрлүүд болох багийн спортыг тусгайлан хөгжүүлэх бодлого зүй ёсоор шаардагдаж байна.

Өргөн уудам нутагтай Монгол орны нөхцөл байдалд тохирсон спортыг бүсчлэн хөгжүүлэх бодлого барьж, баг тамирчдын ур чадварын зэрэглэлд тохирсон уралдаан тэмцээний ангилал, шатлал тогтоон шигшээ уралдаанд оролцуулдаг журамд шилжих;

Спортын клубүүдийг магадлан итгэмжилж, зэрэглэл тогтоож өндөр зэрэглэлийн тамирчид бэлддэг зохион байгуулалт нь жигдэрсэн дэлхийн жишигт ойртсон клуб, сургуульд улсаас дэмжлэг үзүүлдэг журамд шилжих;

Боловсрол, Соёл, шинжлэх ухаан, спортын

яам, Монголын оюутны холбооноос их дээд сургуулийн оюутны дунд спортын секц дугуйлан хичээллэдэг болгох, 7 хоногт 3-5 удаагийн бэлтгэл сургууль хийх боломжоор хангах журамд шилжих;

Спортын төрлүүдийн залгамж халаа бэлтгэх сургалт дасгалжуулалтын төлөвлөлт, стандартыг шинэчлэн боловсруулж биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

Дүгнэлт

Аймаг, нийслэл, дүүрэгт байгуулагдсан хүүхдийн спортын төрөлжсөн сургуулиуд, спортын бэлтгэл анги, секц дугуйлангуудын хичээлийн чанарт онцгой анхаарч, сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөө, стандартыг нэгдсэн системд оруулах;

Хүүхэд хичээллэх заал танхим, багшлах боловсон хүчнийг чанаржуулах ажил зохион байгуулж, хичээл сургалтын чанар чансааг боловсронгуй болгох эрх зүйн акт боловсруулж мөрдөх;

Манай оронд эрчимтэй хөгжиж байгаа спортын төрлүүдийн залгамж халаа бэлтгэх зорилгоор нийслэл хотын дүүрэг бүрд хүүхдийн спортын төрөлжсөн анги, бүлэг, спортын ахлах сургууль, төрөлжсөн сургалттай спортын сургууль байгуулах ажлыг зохион байгуулах;

Ашигласан материал

- Анатолий Бондарчук.А.П. (2017). Управление тренировочным процессом спортсменов высокого класса.с135- 146. Москва: Олимпия пресс
- Никитушкин, В.Г., Квашук, П.В., Вауэр, В.Г. (2005). Организационно-методические основы подготовки спортивного резерва.3. Украин
- Волков.Л.В.(1984).Обучение и воспитание юного спортсмена.-Киев.Здоровья 1.Украин
- Сүхбат, Г. (1997). Монгол улсын өсвөр үеийнхний бие бялдрын өнөөгийн байдал. Цаг үе сэтгүүл 1997. №1.3 хуудас. Улаанбаатар
- Халзан, Д. (2005). Өсвөрийн волейболчид бэлтгэх үндэс.68 хуудас
- Kinda S.Gsher. (1997). *Editor.Coaching volleyball*. The Amerikan Volleyball Association. State United of America